



ᠪᠠᠭᠠᠨᠠᠭᠤᠷ ᠳᠦᠭᠦᠷᠭᠢᠨ
ᠡᠳᠢᠶᠢᠨ ᠵᠠᠰᠠᠭ, ᠨᠢᠶᠭᠮᠢᠶᠢᠨ
ᠪᠠᠶᠢᠳᠠᠯ

БАГАНУУР ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ


2023

1 сар










www.ubstat.mn

[www.facebook.com/Багануур дүүргийн Статистикийн хэлтэс](https://www.facebook.com/Багануур-дүүргийн-Статистикийн-хэлтэс)

www.1212.mn



АГУУЛГА

	Хуудасны дугаар
 ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2019-2023 ОН	3
 АЖИЛ ХАЙГЧ ИРГЭД	4
 НИЙГМИЙН ДААТГАЛ	5
 НИЙГМИЙН ХАЛАМЖ	6
 ЭРҮҮЛ МЭНД	7
 ГЭМТ ХЭРЭГ	9
 ҮНЭ ХАНШ	12
 АЖ ҮЙЛДВЭР	15
 НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	16

ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ХҮСНЭГТ 1. МАЛЫН ТОО, 2022 оны жилийн эцэст, малын төрөл, хороогоор

Үзүүлэлт	Дүүргийн дүн	Үүнээс: хороогоор				
		I	II	III	IV	V
Нийт мал	170805	37109	6214	34590	55283	37609
Үүнээс:						
Тэмээ	54	32	-	20	2	-
Адуу	15545	4115	634	3424	3804	3568
Үхэр	16278	4162	1182	3450	3843	3641
Хонь	84995	17874	2270	17162	29866	17823
Ямаа	53933	10926	2128	10534	17768	12577

ХҮСНЭГТ 2. ХҮН АМ ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2019 I	2020 I	2021 I	2022 I	2023 I
Суурин хүн ам	тоо	29 663	29 342	29433	29431¹	
Төрөлт	тоо	56	56	41	42	55
Нас баралт	тоо	16	15	9	16	9
Шилжиж ирсэн	тоо	25	426 ²	52	50	86
Цэвэр өсөлт	хувь	1.13	1.14	0.11	0.08	0.15 ¹

¹ Өмнөх оны суурин хүн амаас тооцов.

¹ – 2022 оны хүн амын урьдчилсан тоо

² - Улаанбаатар хотод байнга оршин суухаар ирэх иргэдийн шилжилт хөдөлгөөнийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл түр хязгаарласан Нийслэлийн Засаг даргын захирамжийн хугацаа дууссантай холбоотой шилжилт хөдөлгөөний бүртгэл нэмэгдсэн.

ЗУРАГ 1. НУТАГ ДЭВСГЭРИЙН ХЭМЖЭЭ,






БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД


Дүүргийн хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн захиргааны статистик мэдээгээр 2023 оны 1 сарын эцэст 130 иргэн ажил хайж бүртгүүлсэн байна. Дүүргийн хөдөлмөрийн албанд бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэд өнгөрсөн оноос 169 (2.3 дахин бага) хүнээр буурсан байна.

ЗУРАГ 2. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛГӨӨН, I сарын байдлаар




Тайлант сард ажил идэвхтэй хайж байсан 38 иргэн шинээр бүртгүүлсэн бөгөөд үүнээс 21 (55.3%) нь эмэгтэйчүүд байна.

ЗУРАГ 3. АЖИЛ ХАЙГЧ ИРГЭД, ШАЛТГААНААР, I сарын байдлаар



Мөн энэ хугацаанд 4 иргэн ажилд зуучлуулан орсон хязгаарлагдмал хувьцаат компанид 1 иргэн, төсөвт байгууллагад 1 иргэн, улсын болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газарт 1, бусад байгууллагад 1 иргэн тус тус ажилд оржээ.

ЗУРАГ 4. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, насны бүлгээр



Тайлант сард ажил хайж байгаа иргэдийн 13 (10.0%) нь 15-24 насны, 46 (35.4%) нь 25-34 насны залуучууд, 33 (25.4%) нь 35-44 насныхан, 36 (27.7%) нь 45-60 насныхан эзэлж байгаа бөгөөд 60 ба түүнээс дээш насны 2 (1.5%) иргэн байна.

ХҮСНЭГТ 3. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, боловсролоор, I сарын байдлаар

Үзүүлэлт	Ажилгүйдлийн тоо		Үүнээс: эмэгтэй	
	2022 I	2023 I	2022 I	2023 I
Ажилгүйдлийн бүгд	299	130	175	72
Үүнээс:				
Дээд боловсролтой	79	30	59	22
Тусгай дунд боловсролтой	29	9	20	6
Мэргэжлийн анхан шатны боловсролтой	30	14	17	6
Ерөнхий боловсролтой	150	64	77	34
Бага болон боловсролгүй	11	13		4

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 30 (23.1%) нь дээд боловсролтой, 9 (6.9%) нь тусгай дунд боловсролтой, 14 (10.8%) нь мэргэжлийн анхан шатны боловсролтой, 64 (49.2%) нь ерөнхий боловсролтой, 13 (10.0%) нь бага боловсролтой болон боловсролгүй ажээ. Ажил хайгч иргэдийн 72 (55.4%) нь эмэгтэйчүүд байна.


НИЙГМИЙН ДААТГАЛ



Тайлант хугацаанд нийгмийн даатгалын сангийн орлого 2.1 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 1.1 (106.4%) тэрбум төгрөгөөр, зарлага 3.2 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 0.7 (29.7%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Нийт орлогын 1.4 (67.3%) тэрбум төгрөг тэтгэврийн сангаас, 152.0 (7.1%) сая төгрөг тэтгэмжийн сангаас, 145.0 (6.7%) сая төгрөг ҮОМШӨ сангаас, 375.9 (17.5%) сая төгрөг эрүүл мэндийн даатгалын сангаас, 30.0 (1.4%) сая төгрөг ажилгүйдлийн сангаас тус тус төвлөрсөн байна.


ЗУРАГ 5. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, сараар



ХҮСНЭГТ 4. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, эхний I сард

Үзүүлэлт	2022	2023	Өсөлт бууралт	
	I	I	тоо	хувь
	сая төгрөг			
Сангийн орлого, бүгд	1 041.1	2 148.7	1 107.6	106.4
тэтгэврийн сан	699.6	1 445.8	746.2	106.7
тэтгэмжийн сан	73.0	152.0	79.0	108.2
ажилгүйдлийн сан	13.9	30.0	16.1	115.8
ҮОМШӨ ¹ -ний сан	65.5	145.0	79.5	121.4
ЭМД ² -ын сан	189.1	375.9	186.8	98.8
Сангийн зарлага, бүгд	2 442.6	3 169.0	726.4	29.7
тэтгэврийн сан	2 164.2	2 868.3	704.1	32.5
тэтгэмжийн сан	65.2	101.9	36.7	56.3
ҮОМШӨ-ний сан	121.4	144.0	22.6	18.6
ЭМД-ын сан	-	-	-	-
Ажилгүйдлийн сан	91.8	54.8	-37.0	-40.3

ЗУРАГ 6. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГЫН БҮТЭЦ



Тайлант хугацаанд нийгмийн даатгалын сангаас 4842 хүнд 2.8 тэрбум төгрөгийн тэтгэвэр, 356 хүнд 101.9 сая төгрөгийн тэтгэмж, 196 хүнд 144.0 сая төгрөгийн үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэмж, 27 хүнд 54.8 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж тус тус олгосон байна.



НИЙГМИЙН ХАЛАМЖ

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарыг бүхэлд нь цахимжуулах талаар тусгасан. Үүний хүрээнд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийг бүхэлд нь цахимжуулж дүүрэгт санхүүжилт хуваарилалт хийгдэхгүй Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын нэг данснаас зарцуулалт хийгдэж байна.

¹ Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

² Эрүүл мэндийн даатгал

ХҮСНЭГТ 5. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРДАЛ, эхний I сард

Үзүүлэлт	2022	2023	Өсөлт бууралт	
	I	I	тоо	хувь
	сая төгрөг			
Сангийн зарлага	28.2	1 200.7	1 172.5	41.6*
Тэтгэвэр	-	127.2	127.2	-
Тэтгэмж	-	34.0	34.0	-
Амжиргаа дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж	-	28.0	28.0	-
Жирэмсэн эхчүүдийн тэтгэмж	-	8.8	8.8	-
Хүүхдийн мөнгөн тэтгэмж	-	928.5	928.5	-
0-3 хүртэлх настны хүүхэд асаргааны тэтгэмж	-	53.6	53.6	-
Ахмад настанд үзүүлсэн хөнгөлөлт	10.2	2.4	-7.8	-76.5
ХБИргэнд үзүүлсэн хөнгөлөлт	1.6	1.4	-0.2	-12.5
"Хүнс тэжээл" халамжийн хөтөлбөр	16.4	13.2	-3.2	-19.5
Өрх толгойлсон эцэг эхийн тэтгэмж	-	0.4	0.4	-
Ихэр хүүхдийн тэтгэмж	-	2.0	2.0	-
Онцгой тохиолдлын тэтгэмж	-	1.2	1.2	-

*дахин их


Тайлант хугацаанд нийгмийн халамжийн сангаас 443 хүнд 127.2 сая төгрөгийн тэтгэвэр, 369 хүнд 34.0 сая төгрөгийн тэтгэмж, 108 хүнд 28.0 сая төгрөгийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, 244 жирэмсэн эхэд 8.8 сая төгрөгийн тэтгэмж, 9285 хүүхдэд 928.5 сая төгрөгийн хүүхдийн мөнгөн тэтгэмж, 1114 хүнд 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж 53.6 сая төгрөг 15 ахмад настанд 2.4 сая төгрөгийн хөнгөлөлт, тусламж үзүүлж, 1093 хүнийг хүнс тэжээлийн хөтөлбөрт хамруулж 13.2 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй 40 иргэдэд 1.4 сая төгрөгийн хөнгөлөлт, ихэр хүүхдийн тэтгэмж 1 өрхөд 2.0 сая төгрөг, 1 хүнд 1.2 сая төгрөгийн онцгой тохиолдлын тэтгэмж, 1 өрх толгойлсон эх, эцэгт 0.4 сая төгрөг тус тус олгосон байна.



ЭРҮҮЛ МЭНД

Дүүргийн хэмжээнд 2023 оны 1 сарын байдлаар 66 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс 34 (2.1 дахин) өссөн байна. Энэ хугацаанд 19.4 мянган хүн үзлэгт хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 16.2 (45.4%) мянган хүнээр буурсан бол, хэвтэн эмчлүүлсэн 955 хүн байгаа нь өмнөх оны мөн үеэс 116 (13.8%) хүнээр өссөн байна.


ЗУРАГ 7. АМБУЛАТОРИЙН ҮЗЛЭГ, эхний I сард



ХҮСНЭГТ 6. ТӨРСӨН ХҮҮХЭД, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, эхний I сард

Үзүүлэлт	2022 I	2023 I	$\frac{2023.I}{2022.I}$
Амаржсан эхийн тоо	32	66	206.3
Үүнээс бусад аймгийн харьяат	5	27	540.0
Амьд төрсөн хүүхэд	32	68	212.5
Үүнээс бусад аймгийн харьяат	5	27	540.0
Эхийн эндэгдэл	-	-	-
Нэг хүртэлх насандаа эндсэн хүүхэд	1	-	0.0

ЗУРАГ 8. ХАЛДВАРТ ӨВЧИН, сараар



2023 оны 1 сарын байдлаар бэлгийн замын халдварт өвчний 13 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 31.0%-ийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 1 (8.3%) тохиолдлоор өссөн бол цочмог халдварт өвчний 29 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 69.0%-ийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 376 (92.8%) тохиолдлоор буурсан байна.

Дүүргийн дунджаар 10000 хүн тутамд ногдох халдварт өвчнөөр өвчлөгсдийн тоо 14.5 байгаа нь өмнөх оны мөн үеэс 129.3 продицимиллээр буурсан байна.

ХҮСНЭГТ 7. БҮРТГЭГДСЭН ХАЛДВАРТ ӨВЧИН, эхний I сард

Үзүүлэлт	2022 I	2023 I	Өсөлт бууралт
Бэлгийн замын халдварт өвчин	12	13	1
Заг хүйтэн	7	5	-2
Тэмбүү	2	7	5
Трихомониаз	3	1	-2
Цочмог халдварт өвчин	405	29	-376
Цусан суулга	-	2	2
Салхин цэцэг	-	27	27
Ковид-19	405	-	-405
Нийт халдварт өвчин	417	42	-375




ГЭМТ ХЭРЭГ

2023 оны эхний 1 сарын байдлаар дүүргийн хэмжээнд 34 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 6 (21.4%) хэргээр өссөн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 20.7 хувьтай байгаа нь өмнөх оноос 3.1 нэгж хувиар нэмэгдсэн үзүүлэлт юм.

ХҮСНЭГТ 8. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, эхний I сард


Хэргийн төрөл	2022 I	2023 I	Хэргийн өсөлт		Дүнд ээлэх хувь
			тоо	хувь	
Бүртгэгдсэн гэмт хэрэг, бүгд	28	34	6	21.4	100.0
Хүний амь нас хохирсон	3	1	-2	-66.7	2.9
Хүний эрүүл мэндэд хохирол учруулах	15	13	-2	-13.3	38.2
Бусдын эд хөрөнгө хулгайлах	1	4	3	300.0	11.8
Залилан мэхлэх	1	10	9	900.0	29.4
Дээрэмдэх	-	1	1	-	2.9
Хөрөнгө завших, гээгдэл эд зүйл завших	3	1	-2	-66.7	2.9
Бусдын эд хөрөнгө устгах, гэмтээх үрэгдүүлэх	1	1	-	0.0	2.9
Битүүмжилсэн, хураан авсан эд хөрөнгийг завших	-	1	1	-	2.9
Тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих	3	1	-2	-66.7	2.9
Хууль сахиулагчийг эсэргүүцэх	1	1	-	-	2.9
Хэрэг илрүүлэлтийн хувь	17.6	20.7			

ЗУРАГ 9. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, сараар



Бүртгэгдсэн гэмт хэргийн дийлэнх буюу 13 (38.2%) нь хүний эрүүл мэндэд хохирол учруулах хэрэг, 10 (29.4%) нь залилан мэхлэх хэргүүд байна. Тайлант хугацаанд бусдын амь нас хохирсон хэрэг 1 (2.9%) бүртгэгдсэн бөгөөд бусдын эд хөрөнгө хулгайлах хэрэг 4 (11.8%), дээрэмдэх, хөрөнгө завших, бусдын эд хөрөнгийг устгах, битүүмжилсэн хураан авсан хөрөнгийг завших, хууль сахиулагчийг эсэргүүцэх, тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчсөн хэргүүд тус бүр 1 (17.4%) бүртгэгдсэн байна.

ЗУРАГ 10. СОГТУУГААР БОЛОН ГУДАМЖ ТАЛБАЙД ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, сараар



ХҮСНЭГТ 9. ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГДСЭН ГАЗАР, эхний 1 сард


Хэргийн төрөл	2022 I	2023 I	Дүнд эзлэх хувь
Бүртгэгдсэн гэмт хэрэг, бүгд	28	34	100.0
Гэр, орон сууцанд	13	9	26.5
Гудамж талбайд	2	3	8.8
Олон нийтийн газарт	4	5	14.7
Аж ахуйн нэгж байгууллагад	1	6	17.6
Автозамд	2	1	2.9
Бусад	6	10	29.4

Гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг төрлөөр нь авч үзэхэд 9 (26.5%) нь гэр, орон сууцанд, 3 (8.8%) гудамж талбайд, 5 (14.7%) нь олон нийтийн газарт, 6 (17.6%) нь аж ахуйн нэгж байгууллагад, 1 (2.9%) нь автозамд, үлдсэн хэсэг нь буюу 10 нь (29.4%) бусад газарт тус тус үйлдэгдсэн байна.

ЗУРАГ 11. БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, жил бүрийн 1 сарын эцэст




ЗУРАГ 12. ГУДАМЖ ТАЛБАЙД БОЛОН СОГТУУГААР ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, жил бүрийн 1 сарын эцэст



ХҮСНЭГТ 10. ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДСОН ХҮМҮҮС, эхний 1 сард

Үзүүлэлт	Хүний тоо		Өсөлт, бууралт	
	2022 I	2023 I	тоо	хувь
Гэмт хэрэгт холбогдсон хүн	11	12	1	9.1
Үүнээс: эмэгтэйчүүд	3	4	1	33.3
хүүхэд	-	-	-	-
Гэмт хэргийн улмаас хохирсон хүн	30	34	4	13.3
Үүнээс: нас барсан	5	1	-4	-80.0
гэмтсэн	16	13	-3	-18.8
Эрүүлжигдсэн хүний тоо	58	26	-32	-55.2
Баривчлагдсан хүний тоо	9	11	2	22.2
Учирсан хохирол /сая төгрөг/	27.7	54.1	26.4	95.3
Нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ /сая төгрөг/	14.8	16.3	1.5	10.1

ЗУРАГ 13. ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДСОН ИРГЭД, хувиар, эхний 1 сарын байдлаар



2023 оны эхний сард 12 иргэн гэмт хэрэгт холбогдон шалгагдсаны 4 (33.3%) нь эмэгтэйчүүд байна. Тайлант хугацаанд 34 иргэн гэмт хэргийн улмаас хохирсон ба 1 иргэний амь нас хохирч, 13 иргэн гэмтсэн байна. Мөн 26 иргэн согтуугаар зөрчил гарган саатуулагдаж, 11 иргэн баривчлагдсан нь өмнөх оны мөн үеэс саатуулагдсан иргэд 32 (2.2 дахин бага) -оор буурсан бол, баривчлагдсан иргэд 2 (22.2%) иргэнээр нэмэгдсэн байна.

Гэмт хэргийн улмаас 54.1 сая төгрөгийн хохирол учирсны 16.3 (30.1%) сая төгрөгийг нөхөн төлүүлжээ.




ҮНЭ ХАНШ

2023 оны 1 сарын хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүний дундаж үнийг ажиглахад доорх байдалтай байна.


ХҮСНЭГТ 11. ХҮНСНИЙ БАРААНЫ ҮНИЙН АЖИГЛАЛТ, I сарын дундаж үнэ

Хүнсний бараа		Хэмжих нэгж	Хишиг-Уул супер маркет	Марал хүнсний дэлгүүр	Хэрлэн хүнсний зах	Миний нутаг супер маркет
"Алтан тариа" гурил	Дээд	кг	2 850	2 700		2 800
	I зэрэг	кг	2 300	2 150		2 250
	II зэрэг	кг	1 750	1 700		1 800
Будаа	цагаан	кг	4 000	3 800		4 000
	шар	кг	3 240	3 200		3 200
Хонины мах	ястай	кг			8 250	
	цул	кг			11 500	
Үхрийн мах	ястай	кг			11 500	
	цул	кг			13 625	
Адууны мах, ястай		кг			9 000	
Ямааны мах		кг			7 500	
Элсэн чихэр		кг	3 200	3 000		3 300
Сүү /задгай/		л	3 500			
Тараг /задгай/		л	4 000			
Цэцгийн тос, Орос		кг	6 025	5 600		6 050
Байцаа		кг			1 800	
Манжин		кг			1 900	
Төмс	монгол	кг			1 500	
Лууван	монгол	кг			1 800	
Сонгино	хятад	кг			2 750	
	монгол	кг			2 750	
Сармис, булцуу		ш			823	
Огурцы, хятад		кг			10 750	
Помидор, хятад /үрлэн/		кг			9 000	
Ургамлын тос/ siesta/		ш	12 000	10 000		10 500
Өндөг		ш	480	450		450
Талх	Есөн шанд	том 900 гр	ш	2 900	2 900	2 900
		Дунд 700 гр	ш	2 700	2 700	2 700
		жижиг 500 гр	ш	2 200	2 200	2 200
	Атар талх		ш	2 200	2 200	2 200

ЗУРАГ 14. “АЛТАН ТАРИА” ГУРИЛЫН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн I сард



ЗУРАГ 15. НЭГ КГ МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн I сард



ХҮСНЭГТ 12. ЦАХИЛГААНЫ ҮНИЙН ТАРИФ, (НӨАТ-гүй үнэ)

Хэрэглэгчдийн ангилал	Хэмжих нэгж	Тариф (НӨАТ-гүй)
* Айл өрхөд борлуулах цахилгааны тариф		
Энгийн тоолууртай		
• Сарын нийт хэрэглээний 150 кВт.ц	төг/квт.ц	110.5
• Сарын нийт хэрэглээний 151 кВт.ц-аас дээш	төг/квт.ц	130.3
2 тарифт тоолууртай		
• Өдрийн хэрэглээ /06.00-21.00/	төг/квт.ц	116.4
• Орой, шөнийн хэрэглээ /21.00-06.00/	төг/квт.ц	89.2
Сарын суурь тариф	төг/сар	2 000.0
* Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад борлуулах цахилгааны тариф		
Энгийн тоолууртай		
• Сарын нийт хэрэглээний 5000 кВт.ц-аас ихгүй хэрэглээг	төг/квт.ц	164.0
• Сарын нийт хэрэглээний 5000 кВт.ц-аас их хэрэглээг	төг/квт.ц	187.0
3 тарифт тоолууртай /сарын нийт хэрэглээний 5000 кВт.ц-аас ихгүй хэрэглээг		
• Өдрийн хэрэглээ /06.00-17.00/	төг/квт.ц	164.0

• Оройн хэрэглээ /17.00-24.00/	төг/квт.ц	256.0
• Шөнийн хэрэглээ /24.00-06.00/	төг/квт.ц	105.0
3 тарифт тоолууртай /сарын нийт хэрэглээний 5000 кВт.ц-аас ихгүй хэрэглээг		
• Өдрийн хэрэглээ /06.00-17.00/	төг/квт.ц	187.0
• Оройн хэрэглээ /17.00-24.00/	төг/квт.ц	291.0
• Шөнийн хэрэглээ /24.00-06.00/	төг/квт.ц	121.0

* 2019 оны 3 сарын 25-ны өдрөөс мөрдөж буй айл өрхөд борлуулах тариф

*2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрөөс мөрдөж буй үйлдвэр аж ахуйн нэгж байгууллагад борлуулах тариф

ХҮСНЭГТ 13. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ТАРИФ, (НӨАТ-гүй үнэ)

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Айл өрхөд (төгрөг)	Хэмжин нэгж	Аж ахуйн нэгж байгууллагад (төгрөг)	
Дулаан	1м ²	660	1м ³	1260	
Дулааны суурь тариф	40 м ² хүртэл	3 000	-	-	
	40м ² - 80м ²	5 000			
Халуун ус	81м ² -аас дээш	10 000	1 гкал	84 272	
	Өвөл	1 хүн (тоолуургүй)			3 162
		1м ³ (тоолууртай)			1 632
	Зун	1 хүн (тоолуургүй)			4 428
1м ³ (тоолууртай)		1 632			
Цэвэр ус*	1 хүн (тоолуургүй)	1.5	1 л (тоолуургүй)	1.50	
	1 л (тоолууртай)	1.2	1 л (тоолууртай)	1.20	
	Ус түгээх байраар	2.72	1 л (зөөврөөр)	7.5	
Бохир ус*	1 хүн (тоолуургүй)	1.5	1 л (тоолуургүй)	1.8	
	1 л (тоолууртай)	1.2	1 л (тоолууртай)	1.4	
	суурь хураамж	15.0	1 л (зөөврөөр)	1000	

ХҮСНЭГТ 14. МАЛЫН ГАРАЛТАЙ БҮТЭЭГ ДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ

	2019 I	2020 I	2021 I	2022 I	2023 I
	төгрөг				
Адууны шир	19 000	9 000	7 500	6 500	5 500
Үхрийн шир /2.3 метрээс доош/	7 500	5 000	5 000	3 500	2 000
Үхрийн шир /2.3 метрээс дээш/	15 000	8 500	8 000	8 000	4 000
Хонины арьс	2 000	1 000	1 500	2 000	-

ХҮСНЭГТ 15. ТҮЛШ ШАТАХУУНЫ ҮНЭ

Шатахууны нэр төрөл	2019 I	2020 I	2021 I	2022 I	2023 I	Өөрчлөлт	
						төгрөг	хувь
АИ -76,80	1 738	1 810	1 450	2 295	2 420	125	5.4
АИ -92	1 813	1 860	1 470	2 270	2 440	170	7.5
Дизель түлш	2 328	2 490	2 180	2 850	3 950	1 100	38.6

2023 оны 1 сарын байдлаар түлш, шатахууны үнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад АИ-92 бензин 125 (5.4%) төгрөгөөр, АИ-80 бензин 170 (7.5%) төгрөгөөр, дизель түлш 1100 (38.6%) төгрөгөөр тус тус өссөн байна.




АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэлт 2023 оны эхний сард 24.2 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 5.9 (32.7%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

ХҮСНЭГТ 16. АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Биет хэмжээ			Үнийн дүн, сая төгрөг		
		2022 I	2023 I	$\frac{2023.I}{2022.I}$	2022 I	2023 I	$\frac{2023.I}{2022.I}$
Нүүрс олборлолт	м.тн	512.1	526.3	102.8	17 155.4	22 794.1	132.9
Дулаан дамжуулалт	м.гкал	28.2	31.1	110.3	894.0	1 228.1	137.4
Талх үйлдвэрлэлт	тн	17.9	15.4	86.0	30.2	38.7	128.1
Нарийн боов үйлдвэрлэлт	тн	11.7	3.0	25.6	80.9	31.2	38.6
Зайлуулсан хог хаягдал	м.м3	4.4	4.3	97.7	48.3	75.3	155.9
Нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт					18 208.8	24 167.4	132.7


ЗУРАГ 16. АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛТ, сая төгрөг, сараар




Тайлант хугацаанд нүүрс олборлолт өнгөрсөн оны мөн үеэс 14.2 (2.8%) мянган тонноор буюу 5.6 (32.9%) тэрбум төгрөгөөр, дулаан үйлдвэрлэлт 2.9 (10.3%) мянган гкал-аар буюу 334.1 (37.4%) сая төгрөгөөр тус тус өссөн байна. Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлтээс талхны үйлдвэрлэлт өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 2.5 (14.0%) тонноор буурч, үнийн дүнгээр 8.5 (28.1%) сая төгрөгөөр нэмэгдсэн бол, нарийн боовны үйлдвэрлэлт 8.7 (74.4%) тонноор буюу 49.7 (61.4%) сая төгрөгөөр тус тус буурсан үзүүлэлттэй байна. Нарийн боовны үйлдвэрлэлт буурсан шалтгаан нь өнгөрсөн онд сар шинийн баяр 2 сарын эхээр тохиож хэвийн боовыг 1 сард ахиу хэмжээгээр үйлдвэрлэсэн бол 2023 оны сар шинийн баяр 2 сарын сүүлийн

10 хоногт тохиож байгаа тул 1 сард тус бүтээгдэхүүнийг өмнөх оны мөн үеэс бага хэмжээгээр үйлдвэрлэсэнтэй холбоотой болно. Тайлант хугацаанд 4.3 мянган метр куб хог зайлуулсан нь өмнөх оноос 0.1 (2.3%) мянган метр куб-ээр буурсан үзүүлэлттэй байна.

ЗУРАГ 17. ТАЛХ, НАРИЙН БООВ ҮЙЛДВЭРЛЭЛТ, сараар, сая төгрөг



ЗУРАГ 18. НҮҮРС ОЛБОРЛОЛТ, мянган тонн, жил бүрийн 1 сард



НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Тайлант хугацаанд нийтийн аж ахуй үйлчилгээний салбарын орлого 269.8 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 83.0 (44.4%) сая төгрөгөөр өссөн байна. Нийт орлогын 95.4 (35.4%) сая төгрөгийг хүн амаас оруулсан орлого эзэлж


байна.

ХҮСНЭГТ 17. ОРОН СУУЦ НИЙТИЙН АЖ АХУЙН ОРЛОГО, эхний I сард

Үзүүлэлт	2022 I	2023 I	Өсөлт бууралт
	сая төгрөг		
Нийт орлого	186.8	269.8	83.0
Орон сууц	66.0	81.8	15.8
Ус борлуулалт, бүгд	41.9	92.5	50.6

Хүн амд	28.5	35.4	6.9
Аж ахуйн нэгжид	13.4	57.2	43.8
Сувагжуулалт	66.3	85.1	18.8
Бусад	12.6	10.3	-2.3

ЗУРАГ 19. НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛ, сараар, сая төгрөг



ХҮСНЭГТ 18. СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБООДЫН ОРЛОГЫН БИЕЛЭЛТ, эхний I сард

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	ТБ%
	сая төгрөг		
Нийт дүн	57.5	44.1	76.7
Тавлаг өргөө	10.3	7.3	70.9
Маргад өргөө	10.5	7.3	69.5
Сод хөгжил	11.9	10.9	91.6
Шинэ элч	11.0	8.6	78.2
Уурхайчин	6.9	5.7	82.6
Содон суварга	6.9	4.3	62.3

БАГАНУУР ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2023 оны 1 дүгээр сарын 16

WWW.1212.MN СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

Статистик 

Мэдээ, мэдээлэл 

Номын сан 

Мэдлэгээ шалгах
ТОГЛОМ 

Валютын ханш 





©2017

аппликейшнаас


СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛЭЭ АВААРАЙ

Data lab | тооллого судалгааны
микро мэдээллийн сан



Social network

 www.facebook.com/StatisticMongolia/

 www.twitter.com/statistic_mn

Лавлах утас



1900-1212

Цахим шуудан



information@nso.mn